...онгол тутмын хэвлэл
... 12 дугаар сарын 27
№48 /669/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

...онгол Улсын
хууль

902

...онгол Улсын
...енхийлөгчийн
зарлиг

1921

...онгол Улсын
...сгийн газрын
тогтоол

933



## Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай

## Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай

## Талбайг нөөцөд авах тухай

## "Төрийн мэдээлэл" эмхтгэлтэй холбоотой зарим хуулийн заалтууд

★ ★ ★

"Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно".

/Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 3/

☆ ☆ ☆

"Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй".

/Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 3/

☆ ☆ ☆

"Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг "Төрийн мэдээлэл" эмхтгэлд хэвлэн нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эх гэж үзнэ".

/Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 10/

☆ ☆ ☆

"Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхдээ "Төрийн мэдээлэл" эмхтгэлд нийтэлсэн албан ёсны эхийг баримтлах бөгөөд дамжуулан нийтэлснийг албан ёсны бус гэж үзнэ".

/Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 4/

★ ★ ★

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


| | | | |
|---|---|---|---|
| 421. | Застгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 1902 |
| 422. | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 1903 |
| 423. | Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай | | 1903 |
| 424. | Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 1904 |
| 425. | Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 1906 |
| 426. | Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 1915 |
| 427. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 1915 |
| 428. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 1918 |
| 429. | Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 1918 |


### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 430. | Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 07 дугаар дүгнэлтийн тухай | Дугаар 70 | 1919 |
| 431. | Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 08 дугаар дүгнэлтийн тухай | Дугаар 71 | 1920 |


### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


| | | | |
|---|---|---|---|
| 432. | Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 256 | 1920 |
| 433. | Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай | Дугаар 259 | 1921 |
| 434. | Шүүгчийн бүрэн эрхийг сэргээх тухай | Дугаар 260 | 1922 |


### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 435. | Дүрэм батлах тухай | Дугаар 185 | 1923 |
| 436. | Талбайг нөөцөд авах тухай | Дугаар 205 | 1933 |

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

## ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 21.2.8 - 21.2.12 дахь заалт нэмсүгэй:

"21.2.8.нийтийн биеийн тамир, хүн амын идэвхтэй хөдөлгөөнийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх;

21.2.9.нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөний ач холбогдлын талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах;

21.2.10.орон нутгийн захиалгаар эмнэлгийн мэргэжилтний чадавхийг бэхжүүлэх төсөл, арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

21.2.11.анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухааны дэвшилтэт технологийг эзэмшүүлэх зорилгоор эмнэлгийн мэргэжилтнийг гадаадад сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг дэмжих;

21.1.12.эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах."

**2 дугаар зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн "эх үүсвэр" гэсний дараа ", архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь" гэж, мөн зүйлийн 21.2.1 дэх заалтын "архины" гэсний дараа "болон эмийн зохисгүй хэрэглээний" гэж, мөн зүйлийн 21.2.3 дахь заалтын "тэмцэх" гэсний дараа, 21.2.7 дахь заалтын "сэргийлэх" гэсний дараа ", эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх" гэж, мөн зүйлийн 21.2.5 дахь заалтын "архины" гэсний дараа "болон эмийн зохисгүй" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

### ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"6.1.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан 0.6-1.0 хувиар тооцож ногдуулна."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

### ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн "7.4.8-д" гэснийг "7.4.3, 7.4.6, 7.4.8, 7.4.14-т" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр — Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3, 4 дэх хэсэг нэмсүгэй:

"3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдуулах албан татварын хэмжээг Улсын Их Хурлаас баталсан хязгаарт багтаан албан татвар төлөгчийн автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэлтэй аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

4.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтад заасан ачааны автомашины даацын хэмжээ 2 ангилалд давхацсан тохиолдолд түүнийг өмнөх ангиллаар нь тооцож албан татвар ногдуулна."

**2 дугаар зүйл.**Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/4 дүгээр зүйлийн 5 дахь заалт:**

"5/үйлдвэрлэгчээс тусгайлан тоноглосон, хүнсний технологийн тээвэрлэлтийн зориулалт бүхий автомашинаас бусад хүн болон ачаа тээвэрлэхэд зориулагдаагүй тусгай зориулалт бүхий автомашин;"

**2/5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

"1.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг дараахь хэмжээгээр ногдуулна:

| Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл | | Жилд ногдуулах албан татварын дээд, доод хязгаар /төгрөгөөр/ | |
|---|---|---|---|
| | | Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгийн төвийн сумд | Бусад сумд |
| 1 | 2 дугуйтай мотоцикл | 2 000-3 000 | 1 800-2 700 |
| 2 | 3 дугуйтай мотоцикл | 3 000-4 500 | 2 800-4 200 |
| 3 | Суудлын автомашин: | /Цилиндрийн багтаамжийн нэг см³ тутамд төгрөгөөр/ | |
| | а/ 2001 см³ хүртэл | 16-24 | 14-21 |
| | б/ 2001-3001 см³ хүртэл | 18-27 | 16-24 |
| | в/ 3001 см³ болон түүнээс дээш | 22-33 | 20-30 |
| 4 | Микроавтобус /15 хүртэл суудалтай/ | 35 000-52 500 | 28 000-42 000 |
| 5 | Автобус | 52 000-78 000 | 40 000-60 000 |
| 6 | Ачааны автомашин: | | |
| | 1/ 1 хүртэл тн-ын даацтай | 25 000-37 500 | 20 000-30 000 |
| | 2/ 1-2 тн-ын даацтай | 35 000-52 500 | 28 000-42 000 |
| | 3/ 2-3 тн-ын даацтай | 45 000-67 500 | 36 000-54 000 |
| | 4/ 3-5 тн-ын даацтай | 55 000-82 500 | 44 000-66 000 |
| | 5/ 5-8 тн-ын даацтай | 80 000-120 000 | 64 000-96 000 |
| | 6/ 8-10 тн-ын даацтай | 90 000-135 000 | 72 000-108 000 |
| | 7/ 10-20 тн-ын даацтай | 100 000-150 000 | 80 000-120 000 |
| | 8/ 20-30 тн-ын даацтай | 140 000-210 000 | 120 000-180 000 |
| | 9/ 30-40 тн-ын даацтай | 180 000-270 000 | 160 000-240 000 |
| | 10/ 40-50 тн-ын даацтай | 220 000-330 000 | 200 000-300 000 |
| | 11/ 50-60 тн-ын даацтай | 280 000-420 000 | 240 000-360 000 |
| | 12/ 60-70 тн-ын даацтай | 320 000-480 000 | 280 000-420 000 |
| | 13/ 70-80 тн-ын даацтай | 360 000-540 000 | 320 000-480 000 |
| | 14/ 80-90 тн-ын даацтай | 400 000-600 000 | 380 000-570 000 |
| | 15/ 90-100 тн-ын даацтай | 440 000-660 000 | 420 000-630 000 |
| | 16/ 100 тн-оос дээш даацтай | 480 000-720 000 | 440 000-660 000 |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | Тусгай зориулалтын автомашин | 16 000-24 000 | 15 000-22 500 |
| 8 | Трактор, өөрөө явагч бусад хэрэгсэл | 14 000-21 000 | 11 200-16 800 |
| 9 | Бага оврын трактор | 7 000-10 500 | 5 600-8 400 |
| 10 | Чиргүүл /даацын 1 тонн тутамд/ | 5 500-8 250 | 5 500-8 250 |

**3 дугаар зүйл.**Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 1, 3 дугаар зүйлийн "иргэн" гэснийг "хувь хүн" гэж, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Иргэн" гэснийг "Хувь хүн" гэж тус тус өөрчилсугэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр — Улаанбаатар хот

### АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 47.4-47.8 дахь хэсэг нэмсүгэй:

"47.4.Тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч энэ хуулийн 47.3.2-т заасан хувь дээр мөн хуулийн 47.5-д заасан хувийг нэмсэн дүнгээр тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулна.

47.5.Энэ хуулийн 47.4-т заасан нэмэлт төлбөрийн хувийг дараахь байдлаар тодорхойлно:

| № | Бүтээгдэхүүний нэр төрөл | Хэмжих нэгж | Жишиж үнэлэх бүтээгдэхүүн | Зах зээлийн үнийн түвшин /ам.доллараар/ | Бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хүдэр | Баяжмал | Бүтээгдэхүүн |
| 1 | Зэс | тн | Зэс /цэвэр металлаар/ | 0-5000 хүртэл | 0.00 | 0.00 | 0.00 |
| | | | | 5000-6000 хүртэл | 22.0 | 11.0 | 1.00 |
| | | | | 6000-7000 хүртэл | 24.0 | 12.0 | 2.00 |
| | | | | 7000-8000 хүртэл | 26.0 | 13.0 | 3.00 |
| | | | | 8000-9000 хүртэл | 28.0 | 14.0 | 4.00 |
| | | | | 9000 ба түүнээс дээш | 30.0 | 15.0 | 5.00 |
| 2 | Алт | унци | Алт /химийн цэврээр/ | 0-900 хүртэл | - | - | 0.00 |
| | | | | 900-1000 хүртэл | | | 1.00 |
| | | | | 1000-1100 хүртэл | | | 2.00 |
| | | | | 1100-1200 хүртэл | | | 3.00 |
| | | | | 1200-1300 хүртэл | | | 4.00 |
| | | | | 1300 ба түүнээс дээш | | | 5.00 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Цайр | тн | Цайр /цэвэр металлаар/ | 0-1500 хүртэл | 0.00 | 0.00 | 0.00 |
| | | | | 1500-2000 хүртэл | 1.00 | 0.80 | 0.40 |
| | | | | 2000-2500 хүртэл | 2.00 | 1.60 | 0.80 |
| | | | | 2500-3000 хүртэл | 3.00 | 2.40 | 1.20 |
| | | | | 3000-3500 хүртэл | 4.00 | 3.20 | 1.60 |
| | | | | 3500 ба түүнээс дээш | 5.00 | 4.00 | 2.00 |
| 4 | Молибдени | тн | Молибдени | 0-35000 хүртэл | 0.00 | 0.00 | 0.00 |
| | | | | 35000-40000 хүртэл | 1.00 | 0.80 | 0.50 |
| | | | | 40000-45000 хүртэл | 2.00 | 1.60 | 1.00 |
| | | | | 45000-50000 хүртэл | 3.00 | 2.40 | 1.50 |
| | | | | 50000-55000 хүртэл | 4.00 | 3.20 | 2.00 |
| | | | | 55000 ба түүнээс дээш | 5.00 | 4.00 | 2.50 |
| 5 | Төмөр | тн | Төмрийн хүдэр | 0-60 хүртэл | 0.00 | 0.00 | 0.00 |
| | | | | 60-70 хүртэл | 1.00 | 0.70 | 0.40 |
| | | | | 70-80 хүртэл | 2.00 | 1.40 | 0.80 |
| | | | | 80-90 хүртэл | 3.00 | 2.10 | 1.20 |
| | | | | 90-100 хүртэл | 4.00 | 2.80 | 1.60 |
| | | | | 100 ба түүнээс дээш | 5.00 | 3.50 | 2.00 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Гянтболд | тн | Гянтболдын баяжмал | 0-25000 хүртэл | 0.00 | 0.00 | - |
| | | | | 25000-30000 хүртэл | 1.00 | 0.80 | |
| | | | | 30000-35000 хүртэл | 2.00 | 1.60 | |
| | | | | 35000-40000 хүртэл | 3.00 | 2.40 | |
| | | | | 40000-45000 хүртэл | 4.00 | 3.20 | |
| | | | | 45000 ба түүнээс дээш | 5.00 | 4.00 | |
| 7 | Хайлуур жонш | тн | Хайлуур жоншны хүдэр, баяжмал | 0-80 хүртэл | 0.00 | 0.00 | - |
| | | | | 80-90 хүртэл | 1.00 | 0.90 | |
| | | | | 90-100 хүртэл | 2.00 | 1.80 | |
| | | | | 100-110 хүртэл | 3.00 | 2.70 | |
| | | | | 110-120 хүртэл | 4.00 | 3.60 | |
| | | | | 120 ба түүнээс дээш | 5.00 | 4.50 | |
| 8 | Жоншны баяжмал (флотацийн баяжмал ) | тн | Жоншны баяжмал /флотацийн баяжмал/ | 0-200 хүртэл | - | 0.00 | - |
| | | | | 200-230 хүртэл | | 0.70 | |
| | | | | 230-260 хүртэл | | 1.40 | |
| | | | | 260-290 хүртэл | | 2.10 | |
| | | | | 290-320 хүртэл | | 2.80 | |
| | | | | 320 ба түүнээс дээш | | 3.50 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Цагаан тугалга | тн | Цагаан тугалга /цэвэр металлаар/ | 0-17000 хүртэл | 0.00 | 0.00 | 0.00 |
| | | | | 17000-18000 хүртэл | 1.00 | 0.80 | 0.50 |
| | | | | 18000-19000 хүртэл | 2.00 | 1.60 | 1.00 |
| | | | | 19000-20000 хүртэл | 3.00 | 2.40 | 1.50 |
| | | | | 20000-21000 хүртэл | 4.00 | 3.20 | 2.00 |
| | | | | 21000 ба түүнээс дээш | 5.00 | 4.00 | 2.50 |
| 10 | Хар тугалга | тн | Хар тугалга /цэвэр металлаар/ | 0-1500 хүртэл | 0.00 | 0.00 | 0.00 |
| | | | | 1500-1800 хүртэл | 1.00 | 0.80 | 0.40 |
| | | | | 1800-2100 хүртэл | 2.00 | 1.60 | 0.80 |
| | | | | 2100-2400 хүртэл | 3.00 | 2.40 | 1.20 |
| | | | | 2400-2700 хүртэл | 4.00 | 3.20 | 1.60 |
| | | | | 2700 ба түүнээс дээш | 5.00 | 4.00 | 2.00 |
| 11 | Боловсруулаагүй нүүрс | тн | Нүүрс | 0-25 хүртэл | 0.00 | - | - |
| | | | | 25-50 хүртэл | 1.00 | | |
| | | | | 50-75 хүртэл | 2.00 | | |
| | | | | 75-100 хүртэл | 3.00 | | |
| | | | | 100-125 хүртэл | 4.00 | | |
| | | | | 125 ба түүнээс дээш | 5.00 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Баяжуулсан нүүрс (хуурай болон нойтон аргаар технологийн боловсруулалт хийсэн) | тн | Нүүрс | 0-100 хүртэл | - | 0.00 | - |
| | | | | 100-130 хүртэл | - | 1.00 | - |
| | | | | 130-160 хүртэл | - | 1.50 | - |
| | | | | 160-190 хүртэл | - | 2.00 | - |
| | | | | 190-210 хүртэл | - | 2.50 | - |
| | | | | 210 ба түүнээс дээш | - | 3.00 | - |
| 13 | Эцсийн бүтээгдэхүүн (хагас кокс, кокс, хий, шингэн түлш, нүүрс-химийн бүтээгдэхүүн) | тн | Кокс | 0-160 хүртэл | - | - | 0.00 |
| | | | | 160-190 хүртэл | | | 0.50 |
| | | | | 190-210 хүртэл | | | 1.00 |
| | | | | 210-240 хүртэл | | | 1.50 |
| | | | | 240-270 хүртэл | | | 2.00 |
| | | | | 270 ба түүнээс дээш | | | 2.50 |
| 14 | Мөнгө | унци | Мөнгө /химийн цэвэр/ | 0-25 хүртэл | | - | 0.00 |
| | | | | 25-30 хүртэл | | | 1.00 |
| | | | | 30-35 хүртэл | | | 2.00 |
| | | | | 35-40 хүртэл | | | 3.00 |
| | | | | 40-45 хүртэл | | | 4.00 |
| | | | | 45 ба түүнээс дээш | | | 5.00 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | Магнезит | тн | Магнезитийн баяжмал | 0- 100 хүртэл | 0.00 | 0.00 | - |
| | | | | 100-120 хүртэл | 1.00 | 0.90 | |
| | | | | 120-140 хүртэл | 2.00 | 1.80 | |
| | | | | 140-160 хүртэл | 3.00 | 2.70 | |
| | | | | 160-180 хүртэл | 4.00 | 3.60 | |
| | | | | 180 ба түүнээс дээш | 5.00 | 4.50 | |
| 16 | Хөнгөн цагаан | тн | Хөнгөн цагаан / цэвэр металлаар/ | 0-2300 хүртэл | 0.00 | 0.00 | 0.00 |
| | | | | 2300-2600 хүртэл | 1.00 | 0.90 | 0.50 |
| | | | | 2600-2900 хүртэл | 2.00 | 1.80 | 1.00 |
| | | | | 2900-3200 хүртэл | 3.00 | 2.70 | 1.50 |
| | | | | 3200-3500 хүртэл | 4.00 | 3.60 | 2.00 |
| | | | | 3500 ба түүнээс дээш | 5.00 | 4.50 | 2.50 |
| 17 | Газрын ховор элемент | кг | Газрын ховор элементийн ислийн баяжмал | 0-10 хүртэл | 0.00 | 0.00 | - |
| | | | | 10-20 хүртэл | 1.00 | 0.90 | |
| | | | | 20-30 хүртэл | 2.00 | 1.80 | |
| | | | | 30-40 хүртэл | 3.00 | 2.70 | |
| | | | | 40-50 хүртэл | 4.00 | 3.60 | |
| | | | | 50 ба түүнээс дээш | 5.00 | 4.50 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | Фосфорит | тн | баяжмал | 0- 70 хүртэл | 0.00 | 0.00 | 0.00 |
| | | | | 70- 90 хүртэл | 1.00 | 0.90 | 0.50 |
| | | | | 90-110 хүртэл | 2.00 | 1.80 | 1.00 |
| | | | | 110-130 хүртэл | 3.00 | 2.70 | 1.50 |
| | | | | 130-150 хүртэл | 4.00 | 3.60 | 2.00 |
| | | | | 150 ба түүнээс дээш | 5.00 | 4.50 | 2.50 |
| 19 | Цеолит | тн | Цеолит | 0-200 хүртэл | 0.00 | 0.00 | - |
| | | | | 200-250 хүртэл | 1.00 | 0.90 | |
| | | | | 250-300 хүртэл | 2.00 | 1.80 | |
| | | | | 300-350 хүртэл | 3.00 | 2.70 | |
| | | | | 350-400 хүртэл | 4.00 | 3.60 | |
| | | | | 400 ба түүнээс дээш | 5.00 | 4.50 | |
| 20 | Судлын кварц | тн | Кварц | 0-30 хүртэл | 0.00 | 0.00 | - |
| | | | | 30-40 хүртэл | 1.00 | 0.90 | |
| | | | | 40-50 хүртэл | 2.00 | 1.80 | |
| | | | | 50-60 хүртэл | 3.00 | 2.70 | |
| | | | | 60-70 хүртэл | 4.00 | 3.60 | |
| | | | | 70 ба түүнээс дээш | 5.00 | 4.50 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | Чулуун давс | кг | Давс | 0-40 хүртэл | 0.00 | 0.00 | - |
| | | | | 40-50 хүртэл | 1.00 | 0.90 | |
| | | | | 50-60 хүртэл | 2.00 | 1.80 | |
| | | | | 60-70 хүртэл | 3.00 | 2.70 | |
| | | | | 70-80 хүртэл | 4.00 | 3.60 | |
| | | | | 80 ба түүнээс дээш | 5.00 | 4.50 | |
| 22 | Мөсөн шүү | тн | Мөсөн шүү | 0-140 хүртэл | 0.00 | 0.00 | - |
| | | | | 140-150 хүртэл | 1.00 | 0.90 | |
| | | | | 150-160 хүртэл | 2.00 | 1.80 | |
| | | | | 160-170 хүртэл | 3.00 | 2.70 | |
| | | | | 170-180 хүртэл | 4.00 | 3.60 | |
| | | | | 180 ба түүнээс дээш | 5.00 | 4.50 | |
| 23 | Гөлтгөнө | тн | Гөлтгөнө | 0-9 хүртэл | 0.00 | - | - |
| | | | | 9-11 хүртэл | 1.00 | | |
| | | | | 11-13 хүртэл | 2.00 | | |
| | | | | 13-15 хүртэл | 3.00 | | |
| | | | | 15-17 хүртэл | 4.00 | | |
| | | | | 17 ба түүнээс дээш | 5.00 | | |

47.6.Энэ хуулийн 47.3.1, 47.3.2, 47.4, 47.5-д заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах аргачлалыг Засгийн газар батална.

47.7.Ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийг бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарч хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний аль нэгд нь давхардуулахгүйгээр ногдуулна.

47.8.Энэ хуулийн 47.5-д заасан хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлалыг геологи, уул уурхайн болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.".

**2 дугаар зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.2 дахь заалтын "төлбөр" гэснийг "төлбөрийн доод хэмжээ нь" гэж, мөн зүйлийн 47.4-47.7 дахь хэсгийн дугаарыг "47.9-47.12" болгон тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 12 дугаар сарын 02-ны өдөр — Улаанбаатар хот

### ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төрийн аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн "тохирсон байна" гэснийг "тохирсон байх бөгөөд тэдгээрийн албан тушаалын цалингийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 12 дугаар сарын 02-ны өдөр — Улаанбаатар хот

### ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**1/5 дугаар зүйлийн 5.4.30 дахь заалт:**

"5.4.30.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан"

**2/6 дугаар зүйлийн 6.4.16 дахь заалт:**

"6.4.16.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан"

**3/21³ дугаар зүйл:**

**"21³ дугаар зүйл.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан**

21³.1.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан нь энэ хуулийн 7.1-д заасныаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

21³.1.1.шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө;

21³.1.2.замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчилд ногдуулсан захиргааны торгох шийтгэлийг биелүүлж төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө;

21³.1.3.шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр энэ хуулийн 21³.2-т заасан гэмт хэрэгт гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс хохирол барагдуулсан төлбөр.

21³.2.Энэ хуулийн 21³.1-д заасан сангийн хөрөнгийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, Эрүүгийн хуулийн 81.1, 81.2 /Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах/, 91.1, 91.2 /Хүнийг санаатай алах/, 96.1, 96.2 /Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах/, 108.3 /Хүн хулгайлах/, 109.3 /Хүнийг хууль бусаар хорих/, 112.3 /Хүнийг барьцаалах/, 113.3 /Хүн худалдаалах/, 126.2, 126.3 /Хүчиндэх/, 147.3 /Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх/, 177.2 /Зандалчлах/, 178¹.2 /Терроризм/, 251.2, 251.3 /Эрүү шүүлт тулгах/-т заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан дор дурдсан хохиролд нөхөн төлбөр олгоход зарцуулна:

21³.2.1.эмчилгээний зардал;

21³.2.2.оршуулгын зардал;

21³.2.3.хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого.

21³.3.Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн хүчин

тегелдер шийдвэрээр тодорхойлогдоно.

$21^3$.4.Энэ хуулийн $21^3$.1-д заасан сангаас олгох нөхөн төлбөр нь доор дурдсан хэмжээнээс ихгүй байна:

$21^3$.4.1.энэ хуулийн $21^3$.2-т заасан гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гуч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөг;

$21^3$.4.2.энэ хуулийн $21^3$.2-т заасан гэмт хэргийн улмаас хохирогчийн бие махбодид хүнд гэмтэл учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөг.

$21^3$.5.Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийг нэг удаа олгоно.

$21^3$.6.Энэ хуулийн $21^3$.1-д заасан сангаас гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмыг Засгийн газар тогтооно.

$21^3$.7.Гэмт хэргийн хохирогчид энэ хуулийн $21^3$.1-д заасан сангаас олгосон нөхөн төлбөрийг гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдээр уул санд буцаан төлүүлнэ.

$21^3$.8.Гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу зохих төлбөрийг гаргуулна.

$21^3$.9.Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн $21^3$.2-т заасан зориулалтаар өмнөх онд гарсан зардал болон төвлөрсөн орлогын гүйцэтгэлийг харгалзан тухайн жилд улсын төсвөөс санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг төлөвлөнө."

**4/26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсэг:**

"26.7.Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн $21^3$.1-д заасан сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг дараахь шаардлагыг хангасан тохиолдолд гаргана:

26.7.1.хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

26.7.2.гэм буруутай этгээд хохирлыг барагдуулаагүй, эсхүл дутуу барагдуулсан;

26.7.3.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр гарсан.

**2 дугаар зүйл.** Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтын "5.4.29-д" гэснийг "5.4.29, 5.4.30-д" гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогчид уг хууль үйлчилнэ.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 12 дугаар сарын 02-ны өдөр — Улаанбаатар хот

### ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын "шүүхээр баталгаажуулсан" гэсний дараа "Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр," гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2010 оны 12 дугаар сарын 02-ны өдөр баталсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 12 дугаар сарын 02-ны өдөр — Улаанбаатар хот

### ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183 дугаар зүйлийн 183.1 дэх хэсгийн "шүүхээр баталгаажуулсан"

гэсний дараа, 184 дүгээр зүйлийн гарчгийн "захиргааны шийтгэвэр" гэсний өмнө, мөн зүйлийн 184.1 дэх хэсгийн "захиргааны шийтгэвэр" гэсний өмнө, мөн зүйлийн 184.2, 184.3 дахь хэсгийн "арбитрын шийдвэр" гэсний өмнө тус тус "Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр," гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2010 оны 12 дугаар сарын 02-ны өдөр баталсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 12 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 70 | Улаанбаатар хот

### Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 07 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийн "эцэслэн" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ...", мөн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна" гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг 2010 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2010 оны 12 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 71 | Улаанбаатар хот |

**Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 08 дугаар дүгнэлтийн тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын "хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 17.2-т заасан сургалтад хамрагдаагүй, өвбал зохих багц цагийг хангаагүй;" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.", мөн зүйлийн 4 дэх хэсгийн "Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно." гэснийг зөрчсөн байна." гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 08 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг 2010 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 256 | Улаанбаатар хот |

**Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.4 дэх заалт, 58.2 дахь хэсэгт заасныг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн Дамдинсүрэнгийн Нацагийг Баянхонгор аймгийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 12 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 259 | Улаанбаатар хот

### Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Төрийн албаны тухай" хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хавсралтад дурдсан төрийн захиргааны албан хаагчдад төрийн жинхэнэ албан тушаалын тэргүүн түшмэлийн зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2010 оны 12 дугаар сарын 10-ны
өдрийн 259 дүгээр зарлигийн хавсралт

### ТЭРГҮҮН ТҮШМЭЛИЙН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОХ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИД

| д/д | Овог нэр | Эрхэлж байгаа албан тушаал | Албан тушаа-лын зэрэглэл | Олгох зэрэг дэв |
|---|---|---|---|---|
| 1. | Цэрэнхүүгийн Шаравдорж | Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | ТӨ-V | Тэргүүн зэрэг |
| 2. | Чулуунбатын Сайнбилэг | Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга | АА-1 | Тэргүүн зэрэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3. | Дашзэвэгийн Эрдэнэчулуун | Улсын Дээд Шүүхийн Тамгын газрын дарга | АА-1 | Дэд зэрэг |
| 4. | Дугардоржийн Баяндүүрэн | Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны дарга | АА-1 | Дөтгээр зэрэг |
| 5. | Доржийн Насанжаргал | Улсын Их Хурлын Тамгын газрын хэлтсийн дарга | АА-2 | Дөтгээр зэрэг |
| 6. | Цэрэндоржийн Нарантунгалаг | Улсын Их Хурлын Тамгын газрын хэлтсийн дарга | АА-2 | Дөтгээр зэрэг |
| 7. | Гүнэнгийн Чиндэгсүрэн | Улсын Их Хурлын Тамгын газрын хэлтсийн дарга | АА-2 | Дөтгээр зэрэг |
| 8. | Даваанямын Одсүрэн | Улсын Их Хурлын Тамгын газрын байнгын хороодын ажлын албаны дарга | АА-2 | Дөтгээр зэрэг |
| 9. | Цэдэнрагчаагийн Норовдондог | Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгаа, шинжилгээ, ОНХТөвийн дарга | АА-2 | Дөтгээр зэрэг |

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 260 | Улаанбаатар хот |

**Шүүгчийн бүрэн эрхийг сэргээх тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 405 дугаар зарлигаар

шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлсэн, Сэлэнгэ аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч Базарсадын Нацагдоржид холбогдох эрүүгийн хэргийг Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн 2009 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 202 дугаар тогтоолоор хэрэгсэхгүй болгож, цагаатгасан байх тул түүний шүүгчийн бүрэн эрхийг сэргээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙЛӨГЧ** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 185 | Улаанбаатар хот

**Дүрэм батлах тухай**

Барилгын тухай хуулийн 5.1.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Барилгын зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх, барилгын үе шатны ажилд хяналт тавих, ашиглалтад оруулах хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дүрмийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ**
**БАЙГУУЛАЛТЫН САЙД** **Х.БАТТУЛГА**

Засгийн газрын 2010 оны 185 дугаар тогтоолын хавсралт

## БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ТҮҮНД МАГАДЛАЛ ХИЙХ, БАРИЛГЫН ҮЕ ШАТНЫ АЖИЛД ХЯНАЛТ ТАВИХ, АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ХҮРЭЭНД ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Барилгын зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх, барилгын үе шатны ажилд хяналт тавих, ашиглалтад оруулах хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд энэхүү дүрмийг мөрдөнө.

1.2. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд заасан барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх, барилгын үе шатны ажилд хяналт тавих, ашиглалтад оруулах хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг энэ дүрмээр зохицуулахгүй.

1.3. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх нь барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлснээр үүснэ. Бүртгэлийг барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

1.4. Зөвлөх үйлчилгээ үзүүлэхдээ энэ дүрэм болон Иргэний хууль, Барилгын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг удирдлага болгоно.

1.5. Зөвлөх нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, хөрөнгө оруулагч (захиалагч)-ийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, нууцыг чанд хадгалах зарчим баримтална.

1.6. Зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбогдон үүсэх, энэ дүрмээр зохицуулаагүй харилцааг Зөвлөх үйлчилгээ үзүүлэх тухай гэрээ (цаашид "гэрээ" гэх)-гээр нарийвчлан зохицуулна. Гэрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын даалгавар, хөтөлбөр, график, үйлчилгээний хөлс болон гэрээний хугацаа, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага, гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгох нөхцөл, хөрөнгө оруулагч (захиалагч), зөвлөхийн харилцан тохиролцсон бусад асуудлыг тусгана.

1.7. Зөвлөх нь гэрээнд заасан ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн, үр дүнг хөрөнгө оруулагч (захиалагч)-д хүлээлгэн өгнө.

1.8. Зөвлөх нь дараахь зохион байгуулалтын хэлбэртэйгээр үйл ажиллагаа явуулна:

1.8.1. зөвлөх-хувь хүн;

1.8.2. зөвлөх-мэргэжлийн баг;

1.8.3. зөвлөх-компани.

1.9. Энэ дүрэмд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.9.1. "зөвлөх үйлчилгээ" гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн

5.1.15-д заасан тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа төсөл зохиох, хэрэгжүүлэх, сургалт явуулах, техникийн туслалцаа үзүүлэх, түүнчлэн судалгаа шинжилгээ хийх, зураг төсөл боловсруулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих мэргэжлийн үйлчилгээг;

1.9.2. "зөвлөх-мэргэжлийн баг" гэж зөвлөх-хувь хүмүүс тодорхой хугацаанд хамтран ажиллах зорилгоор Иргэний хуулийн 476 дугаар зүйлд заасны дагуу бичгээр байгуулсан хамтран ажиллах гэрээний үндсэн дээр мөн хуулийн 481.1-д заасан бүртгэгдээгүй нөхөрлөлд зохион байгуулагдсаныг.

Хоёр. Зөвлөх сонгон шалгаруулах

2.1. Хөрөнгө оруулагч (захиалагч) нь төрийн байгууллага бол зөвлөхийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулна.

2.2. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулагч (захиалагч) нь зөвлөхийг шууд сонгож болно.

2.3. Зөвлөхийн чадавхийг үнэлэх, урьдчилан сонголтыг явуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12, 13 дугаар зүйлийг удирдлага болгоно.

2.4. Хөрөнгө оруулагч (захиалагч) зөвлөхийг сонгохдоо мэргэжлийн ур чадварыг нь харгалзана.

2.5. Дараах этгээдийг зөвлөхөөр авч ажиллуулахыг хориглоно:

2.5.1. захиалагч, гүйцэтгэгч болон барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх, барилгын үе шатны ажилд хяналт тавих, ашиглалтад оруулах ажилд оролцогч бусад этгээдтэй гэр бүл, төрөл садангийн холбоотой;

2.5.2. захиалагч, гүйцэтгэгч болон барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх, барилгын үе шатны ажилд хяналт тавих, ашиглалтад оруулах ажилд оролцогч компанийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигч;

2.5.3. гэр бүл, төрөл садан нь тухайн компанийн эрх бүхий этгээд (төлөөлөн удирдах зөвлөл, хамтын гүйцэтгэх удирдлагын гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн).

Гурав. Зөвлөх үйлчилгээний ангилал

3.1. Зөвлөх үйлчилгээг дараахь байдлаар ангилна:

3.1.1. хөрөнгө оруулалтын судалгаа хийх;

3.1.2. хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл, норм, норматив боловсруулалтын болон архитектур төлөвлөлт, инженерийн техникийн шийдлийн түвшинг тогтоож, магадлал хийж баталгаажуулах;

3.1.3. барилгын ажил гүйцэтгэх явц, ашиглалтын үеийн чанар, аюулгүй байдлын төлөвт хяналт тавин үзлэг хийж, үнэлэлт дүгнэлт өгөх;

3.1.4. барилгын материалын үйлдвэрлэлийн технологи, хийц бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын баталгаажуулалт хийх;

3.1.5. барилгын ажлын механикжуулалт, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, оношилгоо, засвар, техникийн үйлчилгээ, тохируулга, зүгшрүүлэлт хийх технологи, аргачлал боловсруулах;

3.1.6. төслийн удирдлага, зохион байгуулалт, үйлдвэрлэл технологийн зөвлөгөө өгөх.

Дөрөв. Зөвлөх үйлчилгээний ажлын бүрдэл

4.1. Хөрөнгө оруулалтын судалгаа хийх зөвлөх үйлчилгээнд дараахь ажил хамаарна:

4.1.1. хөрөнгө оруулалтын урьдчилсан судалгаа хийх;

4.1.2. төслийг хэрэгжүүлэх боломж, үндэслэлийг тогтоох;

4.1.3. төслийн техник-эдийн засгийн үндэслэл, төсвийн төслийг боловсруулах;

4.1.4. төсөл хэрэгжүүлэх байгууллагын талаар санал боловсруулах.

4.2. Хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл, норм, норматив боловсруулалтын болон архитектур төлөвлөлт, инженерийн техникийн шийдлийн түвшинг тогтоож,

магадлал хийж баталгаажуулах зөвлөх үйлчилгээнд дараах ажил хамаарна:

4.2.1. барилгын дүрэм, норм, нормативын стандарт, хийц хэсгийн альбом, каталоги боловсруулалтын түвшинг тогтоох;

4.2.2. барилгын зураг, төслийн даалгавар боловсруулах;

4.2.3. инженер геологи, геодезийн хайгуул, судалгааны ажлын чанарын түвшинг тогтоох;

4.2.4. технологи болон инженерийн ажлын дэлгэрэнгүй тойм-эх загвар зураг гаргах буюу техникийн зураг төсөл боловсруулах;

4.2.5. инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулахад ажлын тоо хэмжээг тодорхойлж, төсөвт өртгийн тооцоо хийж тогтоох;

4.2.6. барилгын ажилд тавигдах техникийн шаардлага боловсруулах;

4.2.7. тендерийн баримт бичгийн төсөл боловсруулах;

4.2.8. архитектур төлөвлөлт, инженерийн техникийн шийдлийн түвшинг тогтоох, магадлал хийх;

4.2.9. хот байгуулалтын баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл, техник-эдийн засгийн үндэслэл, төсөв тооцоонд судалгаа хийж, түвшинг тогтоох.

4.3. Барилгын ажлын гүйцэтгэлийн явцад үнэлэлт, дүгнэлт өгөх зөвлөх үйлчилгээнд дараах ажил хамаарна:

4.3.1. барилга байгууламжийн ашиглалтын үеийн чанар, аюулгүй байдалд үнэлэлт дүгнэлт өгөх;

4.3.2. барилга байгууламжийн чанар, технологид үнэлэлт дүгнэлт өгөх, тухайн барилга байгууламж батлагдсан зураг төсөл, техникийн шаардлагын дагуу баригдаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх;

4.3.3. технологийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, тохиргоо, эгшрүүлэлтийн үйл ажиллагааны технологи, аргачлал боловсруулах.

4.4. Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи, хийц бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын баталгаажуулалт хийх зөвлөх үйлчилгээнд дараах ажил хамаарна:

4.4.1. барилгын материалын үйлдвэрийн технологийн тохируулга, зүгшрүүлэлт хийх;

4.4.2. тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар техникийн үйлчилгээ, технологийн зааврыг мөрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

4.4.3. тухайн барилгын ажилд шаардагдах материалын зах зээлийн эрэлт хэрэгцээ, үйлдвэрлэлийн технологийн дэвшил, аюулгүй ажиллагаа, хийц бүтээц, эдлэхүүний нэр төрөл, чанар, стандарт, ашиглалтын үеийн аюулгүй байдлын баталгаажуулалт хийж, эрдэс түүхий эд, материалын ашиглалт, боловсруулах технологи, түүхий эд материалын болон бүтээгдэхүүний орцын нормыг тодорхойлох;

4.4.4. үйлдвэрлэлийн технологийн заавар, бүтээгдэхүүний стандарт, бүтээгдэхүүнийг барилгад хэрэглэх аргачилсан заавар, үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, барилгын материалын үйлдвэрийн тоног төхөөрөмж угсрах, туршилт, тохируулга хийх арга ажиллагаа, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн турших.

4.5. Барилгын ажлын механикжуулалт, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, оношилгоо, засвар, техникийн үйлчилгээ, тохируулга, зүгшрүүлэлт хийх зөвлөх үйлчилгээнд дараах ажил хамаарна:

4.5.1. машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны талаар норматив баримт бичгийн төсөл боловсруулах;

4.5.2. өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэлийн талаар техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах;

4.5.3. инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, төслийн ажлын тоо хэмжээг тодорхойлох, өртгийн тооцоо хийлгэх;

4.5.4. өргөх байгууламжийн угсралт, засвар, техникийн үйлчилгээ, оношилгоо, тохируулга, зүгшрүүлэлтийн ажлыг гүйцэтгүүлэх.

4.6. Төслийн удирдлага, зохион байгуулалт, технологийн зөвлөх

үйлчилгээнд дараах ажил хамаарна:

4.6.1. төслийн баримт бичгийн боловсруулалтыг хэрэгжилтийн үе шат бүрээр хянаж, баталгаажуулах ажиллагааны горим дараалдлыг мөрдүүлэх;

4.6.2. зураг төслийн болон барилгын төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил, гүйцэтгэлийн чанар технологийн хяналтыг хэрэгжүүлэх;

4.6.3. төслийн багийн удирдамжийг боловсруулж, хэрэгжүүлэх явцад зөвлөгөө өгөх;

4.6.4. төслийн ажил, үйлдвэрлэлийн зохион байгуулалт, технологийн процессын төлөвлөгөөнүүдийн биелэлтийг хянах;

4.6.5. төслийн хэрэгжилтийн явцад гарсан өөрчлөлтийн үр дүнг тогтоох;

4.6.6. төслийн хэрэгжилтийг шуурхай удирдлагаар хангах, эрсдэлийн түвшинг тогтоох;

4.6.7. техник технологийн сонголт, шийдлийн талаар санал боловсруулах;

4.6.8. төслийн үе шатны болон эцсийн тайлан тооцоо, өгөөжийг тайлагнах, дүгнэх.

Тав. Зөвлөх-компани

5.1. Зөвлөх-компани нь энэ дүрмийн 3.1-д заасан зөвлөх үйлчилгээг үзүүлнэ.

5.2. Зөвлөх-компани зөвлөх үйлчилгээ үзүүлэх талаар дараах эрх эдэлнэ:

5.2.1. шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн магадлалын шалгалтыг хийлгэх. Шалгалтын явцад хөрөнгө оруулагч (захиалагч)-тай хамтран ажиллаж, түүнд шаардлагатай туслалцаа үзүүлэх;

5.2.2. хөрөнгө оруулагч (захиалагч)-аас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр гэрээнд заасан зарим ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх;

5.2.3. гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хөрөнгө оруулагч (захиалагч)-ийн эзэмшлийн эд хөрөнгийг түүний зөвшөөрөлтэйгээр ашиглах;

5.2.4. гэрээнд заасан ажлыг зохих ёсоор гүйцэтгэсэн боловч хөрөнгө оруулагч (захиалагч) гэрээг хугацаанаас өмнө цуцалсан тохиолдолд өөрт учирсан хохирлоо арилгуулахаар шаардах;

5.2.5. хууль тогтоомжид заасан бусад эрх.

5.3. Зөвлөх компани зөвлөх үйлчилгээ үзүүлэх талаар дараах үүрэг хүлээнэ:

5.3.1. гэрээнд заасан ажлын явц, үр дүнг хөрөнгө оруулагч (захиалагч)-ийн хүсэлтээр цаг тухайд нь танилцуулах;

5.3.2. гэрээний хугацаа дуусгавар болсны дараа гэрээнд заасны дагуу хөрөнгө оруулагч (захиалагч)-аас авч ашиглаж байсан бүх эд хөрөнгийг буцааж хүлээлгэн өгөх;

5.3.3. энэ гэрээний 5.2.4-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу учирсан хохирлыг нөхөн төлөх;

5.3.4.Ажиллах хүч, нөөцийн талаар:

5.3.4.1. гэрээнд туссан мэргэжилтнүүдийн жагсаалтад байгаа мэргэжилтнийг солих зайлшгүй шаардлагатай тохиолдолд мэдлэг боловсрол, мэргэжлийн хувьд чадварлаг хүнийг томилон ажиллуулах бөгөөд уг ажилтныг солихтой холбоотой тээврийн болон бусад зардлыг зөвлөх өөрөө хариуцах;

5.3.4.2. гэрээнд заасны дагуу өөрийн болон туслан гүйцэтгэгчийн бүх гэрээт ажил, тайлан, мэдээг хөрөнгө оруулагч (захиалагч)-ийн өмнө бүрэн хариуцах.

5.3.5. Нөхөн төлбөр, даатгалын талаар:

5.3.5.1. хөрөнгө оруулагч (захиалагч)-аас нийлүүлсэн, эсхүл түүний санхүүжилтээр худалдан авсан, өөрийн эзэмшилд байгаа эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, учруулсан гэм хорыг арилгах;

5.3.5.2. хөрөнгө оруулагч (захиалагч)-ийн

санхүүжилтээр худалдан авах бүх бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхийн зөрчилгүй болохыг баталж, учрах үр дагаврыг хөрөнгө оруулагч (захиалагч)-ийн өмнө бүрэн хариуцах.

5.3.6. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Зургаа. Зөвлөх-мэргэжлийн баг

6.1. Зөвлөх-мэргэжлийн баг нь энэ дүрмийн 3.1-д заасан зөвлөх үйлчилгээг үзүүлнэ.

6.2. Зөвлөх-мэргэжлийн баг нь зөвлөх үйлчилгээ үзүүлэх талаар энэ дүрмийн 5.2, 5.3-т заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Долоо. Зөвлөх-хувь хүн

7.1. Зөвлөх-хувь хүн нь дараахь чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлнэ:

7.1.1. гүйцэтгэх ажлын талаар гаргах судалгаа тооцоо, нэр төрлийг бэлтгэх, төсөлд шүүмж, нэмэлт, магадлал хийх;

7.1.2. салбарын бодлого тодорхойлох, судалгаа хийх, хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад оролцуулах буюу туслуулах;

7.1.3. зарим тусгай ажлыг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулагч (захиалагч), банкны болон санхүүжүүлэгчийн мэргэжилтнүүдэд төсөв, тооцооны талаар ямар нэгэн тусгай үйлчилгээ үзүүлэх;

7.1.4. аливаа төслийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулагч (захиалагч) зээлдэгчид богино хугацааны зөвлөгөө, мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

7.1.5. энэ дүрмийн 3.1-д заасан ажлуудыг хэсэгчлэн гүйцэтгэх.

7.2. Зөвлөх-хувь хүн нь зөвлөх үйлчилгээ үзүүлэх талаар энэ дүрмийн 5.2, 5.3-т заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Найм. Зөвлөх үйлчилгээний ажлын үр дүн

8.1. Зөвлөх үйлчилгээний ажлын үр дүн болон зөвлөхийн боловсруулсан, эмхэтгэсэн зөвлөх үйлчилгээтэй холбоотой баримт бичиг, тайлан, албан захидал, хэвлэмэл материал, компьютерийн программ хангамж, газрын зураг, ажлын зураг, техникийн шаардлага, статистик мэдээ, техникийн өгөгдлүүд хөрөнгө оруулагч (захиалагч)-ийн өмч байна.

Ес. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх тухай гэрээ

9.1. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх тухай гэрээг байгуулахдаа Монгол Улсын Иргэний хууль болон Олон улсын зөвлөх инженерүүдийн нийгэмлэг /FIDIC/-ийн загвар гэрээг үндэслэнэ.

Арав. Зөвлөх үйлчилгээний зардал, санхүүжилт

10.1. Хөрөнгө оруулагч (захиалагч) нь зөвлөх үйлчилгээний зардлыг тухайн төслийн зардлын нэг хэсэг болгон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган санхүүжүүлнэ. Зардлыг зах зээлийн тухайн үеийн ханшаар нарийвчлан тооцох бөгөөд төслийн төсөвт өртгийн 5 хувиас багагүйгээр тооцож, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт тусгана.

10.2. Зөвлөхийн зардлыг ажлын нэр төрлийн дэлгэрэнгүй задаргааны үндсэн дээр тооцно. Тооцоход бэрхшээлтэй зарим зардлыг бөөн дүнгээр тусгаж болно. Зардлыг ямар байдлаар тусгахыг хөрөнгө оруулагч (захиалагч) зөвлөх сонгохоос өмнө шийдвэрлэж, зардлын бүтцийг тендерийн баримт бичигт дэлгэрэнгүй тусгана.

Арван нэг. Бүртгэлээс хасах

11.1. Дараах тохиолдолд зөвлөхийг бүртгэлээс хасна:

11.1.1. компани татан буугдсан, эсхүл иргэн нас барсан;

11.1.2. бүртгүүлэхдээ хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

11.1.3. барилгын хууль тогтоомжийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;

11.1.4. материал, тоног төхөөрөмж, техникийн норм, нормативын баримт бичгээр хангагдаагүй.

Арван хоёр. Мэдээллийн сан

12.1. Барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээдийн тухай мэдээллийн санг хөтөлнө. Сан дараах мэдээллийг агуулна:

12.1.1. зөвлөхийн нэр, үзүүлж байгаа үйлчилгээний төрөл, үйл ажиллагааны чиглэлийн тухай;

12.1.2. зөвлөх нь компани бол компанийн бүтэц, зохион байгуулалт, ажлын туршлагын тухай;

12.1.3. зөвлөх нь компани бол компанийн мэргэжилт-

нүүдийн жагсаалт, тэдгээрийн дадлага туршлага, мэргэжлийн ур чадварын тухай;

12.1.4. зөвлөх нь компани бол компанийн санхүүгийн чадавхийн тухай;

12.1.5. зөвлөх нь компани бол компанийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамжийн тухай.

12.2. Барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ дүрмийн 12.1-д заасан мэдээллийг цахим хэлбэрт оруулж, мэдээллийн сан үүсгэх, түгээх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангана.

12.3. Цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журмыг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2010 оны 8 дугаар сарын 18-ны өдөр | Дугаар 205 | Улаанбаатар хот |

**Талбайг нөөцөд авах тухай**

Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.7, 13.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажил хийж байгаа 1 дүгээр хавсралтад заасан талбайг нөөцөд авсугай.

2. Улсын төсвийн хөрөнгөөр геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажил хэрэгжүүлэх хавсралтад заасан талбайг нөөцөд авсантай холбогдуулан тусгай хамгаалалттай газар нутагт зураглалын ажил, геологийн судалгаа явуулахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч, хамгаалалтын захиргаатай гэрээ байгуулж ажиллахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **С.БАТБОЛД**

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД** **Д.ЗОРИГТ**

Засгийн газрын 2010 оны 205 дугаар
тогтоолын хавсралт

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ГЕОЛОГИЙН 1:50000-НЫ МАСШТАБЫН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖЛЫН ТАЛБАЙ**

| № | Талбайн нэр /лист/ | Аймаг, сумын нэр | Солбицол | Нөөцөд авах талбайн хэмжээ /кв.км/ | Нөөцөд авсан зорилго | Нөөцөд байлгах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | | 6 |
| 1 | Согоотын нуруу-50 М-45-107-А,Б,В,Г М-45-108-А, Б (2010-2012) Код: СН-50 | Баян-Өлгий аймгийн Бугат, Цагааннуур, Улаан хус, Цэнгэл сум | 1. 89 00 00 49 00 00<br>2. 89 00 00 49 20 00<br>3. 90 00 00 49 20 00<br>4. 90 00 00 49 10 00<br>5. 89 30 00 49 10 00<br>6. 89 30 00 49 00 00 | 2032.5 | 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийх | 2013 он хүртэл |
| 2 | Нарт толгой-50 М-46-92-А, Б,В,Г М-46-93-А, Б, В,Г (2010-2012) Код: НТ-50 | Увс аймгийн Хяргас, Цагаанхайрхан, Баруунтуруун, Малчин сум | 1. 94 28 40.64 49 26 40.73<br>2. 94 28 40.63 49 22 41.74<br>3. 94 22 00 49 22 49.29<br>4. 94 22 00 49 25 00<br>5. 93 48 30 49 25 00<br>6. 93 48 30 49 20 00<br>7. 93 30 00 49 20 00<br>8. 93 30 00 49 40 00<br>9. 94 30 00 49 40 00<br>10. 94 30 00 49 32 01.03<br>11. 94 29 59.64 49 32 00.78<br>12. 94 26 19.53 49 31 14.81<br>13. 94 22 34.64 49 26 40.74 | 2187.1 | 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийх | 2013 он хүртэл |
| 3 | Дүнгэн уул-50 М-47-63-А,Б,В, Г М-47-73-А,Б,В, Г (2010-2012) Код: ДУ-50 | Завхан аймгийн Баянхайрхан, Баянтэс сум | 1. 96 04 15.77 50 00 38.76<br>2. 96 04 17.46 50 00 39.15<br>3. 96 04 37.84 50 00 39.65<br>4. 96 04 58.59 50 00 35.73<br>5. 96 05 02.78 50 00 29.11<br>6. 96 05 08.45 50 00 23.12<br>7. 96 05 15.03 50 00 18.28<br>8. 96 05 24.36 50 00 12.67<br>9. 96 05 27.63 50 00 08.82<br>10. 96 05 29.47 50 00 06.64<br>11. 96 05 34.8 49 59 51.36<br>12. 96 05 44.62 49 59 46.22<br>13. 96 05 51.91 49 59 40.45<br>14. 96 06 01.22 49 59 37.25 | 2501.7 | 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийх | 2013 он хүртэл |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 15. 96 06 25.21 49 59 20.61 | | | |
| | | | 16. 96 06 56.33 49 59 21.09 | | | |
| | | | 17. 96 07 12.15 49 59 14.11 | | | |
| | | | 18. 96 07 33.78 49 59 10.71 | | | |
| | | | 19. 96 07 36.5 49 59 10.54 | | | |
| | | | 20. 96 07 44.74 49 59 11.63 | | | |
| | | | 21. 96 07 55.91 49 59 11.06 | | | |
| | | | 22. 96 08 04.68 49 59 17.43 | | | |
| | | | 23. 96 08 23.83 49 59 18.64 | | | |
| | | | 24. 96 08 25.62 49 59 19.15 | | | |
| | | | 25. 96 08 27.37 49 59 19.63 | | | |
| | | | 26. 96 08 41.11 49 59 19.77 | | | |
| | | | 27. 96 08 53.67 49 59 24.44 | | | |
| | | | 28. 96 09 12.62 49 59 24 | | | |
| | | | 29. 96 09 22.18 49 59 21.62 | | | |
| | | | 30. 96 09 27.15 49 59 20.9 | | | |
| | | | 31. 96 09 24.29 49 59 21.31 | | | |
| | | | 32. 96 09 27.15 49 59 20.9 | | | |
| | | | 33. 96 09 32.83 49 59 20.07 | | | |
| | | | 34. 96 09 51.42 49 59 17.35 | | | |
| | | | 35. 96 09 57.9 49 59 18.56 | | | |
| | | | 36. 96 10 11.52 49 59 21.12 | | | |
| | | | 37. 96 10 38.64 49 59 21.78 | | | |
| | | | 38. 96 10 46.35 49 59 18.26 | | | |
| | | | 39. 96 10 56.48 49 59 18.78 | | | |
| | | | 40. 96 11 06.24 49 59 17.67 | | | |
| | | | 41. 96 11 26.01 49 59 16.93 | | | |
| | | | 42. 96 11 30.2 49 59 16.72 | | | |
| | | | 43. 96 11 51.78 49 59 18.41 | | | |
| | | | 44. 96 12 05.16 49 59 13.87 | | | |
| | | | 45. 96 12 16.53 49 59 02.13 | | | |
| | | | 46. 96 12 22.22 49 58 56.26 | | | |
| | | | 47. 96 12 29.99 49 58 54.62 | | | |
| | | | 48. 96 12 42.87 49 58 55.26 | | | |
| | | | 49. 96 12 52.33 49 58 50.45 | | | |
| | | | 50. 96 12 57.65 49 58 50.13 | | | |
| | | | 51. 96 13 18.23 49 58 38.6 | | | |
| | | | 52. 96 13 48.79 49 58 46.38 | | | |
| | | | 53. 96 13 51.93 49 58 47.18 | | | |
| | | | 54. 96 14 05.27 49 58 48.87 | | | |
| | | | 55. 96 14 24.26 49 58 48.36 | | | |
| | | | 56. 96 14 35.03 49 58 48.83 | | | |
| | | | 57. 96 14 54.45 49 58 45.85 | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 58. 96 15 00.33 49 58 45.71 | | | |
| | | | 59. 96 15 32.57 49 58 38.32 | | | |
| | | | 60. 96 15 42.85 49 58 33.93 | | | |
| | | | 61. 96 15 53.88 49 58 24.54 | | | |
| | | | 62. 96 15 49.27 49 58 15.1 | | | |
| | | | 63. 96 15 57.78 49 58 08.8 | | | |
| | | | 64. 96 16 06.54 49 57 57.97 | | | |
| | | | 65. 96 16 09.06 49 57 54.86 | | | |
| | | | 66. 96 16 39.82 49 57 38.18 | | | |
| | | | 67. 96 16 47.38 49 57 22.5 | | | |
| | | | 68. 96 16 50.4 49 57 19.51 | | | |
| | | | 69. 96 17 02.88 49 57 21.53 | | | |
| | | | 70. 96 17 12.78 49 57 22.18 | | | |
| | | | 71. 96 17 41.58 49 57 24.06 | | | |
| | | | 72. 96 17 59.06 49 57 16.05 | | | |
| | | | 73. 96 17 59.67 49 57 15.81 | | | |
| | | | 74. 96 17 59.69 49 57 15.6 | | | |
| | | | 75. 96 18 09.26 49 57 08.66 | | | |
| | | | 76. 96 18 10.71 49 57 05.08 | | | |
| | | | 77. 96 18 14.8 49 56 54.97 | | | |
| | | | 78. 96 17 55.84 49 56 43.41 | | | |
| | | | 79. 96 18 08.04 49 56 40.68 | | | |
| | | | 80. 96 18 22.4 49 56 40.41 | | | |
| | | | 81. 96 18 49.81 49 56 42.24 | | | |
| | | | 82. 96 19 04.23 49 56 40.84 | | | |
| | | | 83. 96 19 09.87 49 56 44.42 | | | |
| | | | 84. 96 19 18.86 49 56 54.76 | | | |
| | | | 85. 96 19 24.37 49 56 55.69 | | | |
| | | | 86. 96 19 28.31 49 56 56.36 | | | |
| | | | 87. 96 19 36.49 49 56 50.55 | | | |
| | | | 88. 96 19 52.09 49 56 42.05 | | | |
| | | | 89. 96 20 03.45 49 56 39.04 | | | |
| | | | 90. 96 20 17.14 49 56 28.81 | | | |
| | | | 91. 96 20 20.93 49 56 04.13 | | | |
| | | | 92. 96 20 21.36 49 56 01.33 | | | |
| | | | 93. 96 20 16.92 49 55 54.68 | | | |
| | | | 94. 96 20 31.74 49 55 49.5 | | | |
| | | | 95. 96 20 45.01 49 55 44.86 | | | |
| | | | 96. 96 20 51.9 49 55 35.47 | | | |
| | | | 97. 96 20 43.78 49 55 26.93 | | | |
| | | | 98. 96 20 41.09 49 55 23.97 | | | |
| | | | 99. 96 20 38.96 49 55 13.4 | | | |
| | | | 100. 96 20 25.23 49 54 55.04 | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 101. 96 20 48.97 49 54 32.31 | | | |
| | | | 102. 96 20 50.76 49 54 28.92 | | | |
| | | | 103. 96 20 56.22 49 54 23.87 | | | |
| | | | 104. 96 20 54.82 49 54 19.21 | | | |
| | | | 105. 96 21 03.7 49 54 15.62 | | | |
| | | | 106. 96 22 01.19 49 54 04.83 | | | |
| | | | 107. 96 22 06.63 49 54 03.43 | | | |
| | | | 108. 96 22 08.33 49 54 02.28 | | | |
| | | | 109. 96 22 08.17 49 54 02.36 | | | |
| | | | 110. 96 22 08.32 49 54 02.28 | | | |
| | | | 111. 96 22 11.75 49 53 59.96 | | | |
| | | | 112. 96 22 18.2 49 53 55.56 | | | |
| | | | 113. 96 22 25.17 49 53 53.75 | | | |
| | | | 114. 96 22 27.48 49 53 53.15 | | | |
| | | | 115. 96 22 37.2 49 53 52.61 | | | |
| | | | 116. 96 22 46.21 49 53 49.51 | | | |
| | | | 117. 96 22 58.12 49 53 49.81 | | | |
| | | | 118. 96 23 10.01 49 53 37.93 | | | |
| | | | 119. 96 23 18.46 49 53 32.18 | | | |
| | | | 120. 96 23 19.72 49 53 28.54 | | | |
| | | | 121. 96 23 21.42 49 53 23.58 | | | |
| | | | 122. 96 23 26.05 49 53 21.74 | | | |
| | | | 123. 96 23 38.77 49 53 19.73 | | | |
| | | | 124. 96 23 44.12 49 53 18.88 | | | |
| | | | 125. 96 23 51.25 49 53 11.01 | | | |
| | | | 126. 96 23 51.47 49 53 04.12 | | | |
| | | | 127. 96 24 05 49 52 59.13 | | | |
| | | | 128. 96 24 25.97 49 52 50.88 | | | |
| | | | 129. 96 24 50.88 49 52 41.29 | | | |
| | | | 130. 96 24 51.21 49 52 41.21 | | | |
| | | | 131. 96 24 51.38 49 52 41.14 | | | |
| | | | 132. 96 25 02.88 49 52 36.74 | | | |
| | | | 133. 96 25 12.85 49 52 40.21 | | | |
| | | | 134. 96 25 17.21 49 52 39.87 | | | |
| | | | 135. 96 25 28.75 49 52 33.34 | | | |
| | | | 136. 96 25 51.81 49 52 37.98 | | | |
| | | | 137. 96 26 02.35 49 52 37.26 | | | |
| | | | 138. 96 26 08.4 49 52 43.41 | | | |
| | | | 139. 96 26 14.15 49 52 57.8 | | | |
| | | | 140. 96 26 40.93 49 53 03.75 | | | |
| | | | 141. 96 26 59.56 49 53 15.97 | | | |
| | | | 142. 96 27 15.49 49 53 20.39 | | | |
| | | | 143. 96 27 19.14 49 53 26.58 | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 144. 96 27 46.59 49 53 45.96 | | | |
| | | | 145. 96 27 44 49 53 54.49 | | | |
| | | | 146. 96 27 44.89 49 53 56.73 | | | |
| | | | 147. 96 27 46.54 49 54 03.43 | | | |
| | | | 148. 96 27 45.19 49 54 10.19 | | | |
| | | | 149. 96 27 47.55 49 54 16.8 | | | |
| | | | 150. 96 27 47.35 49 54 16.95 | | | |
| | | | 151. 96 27 41.76 49 54 22.76 | | | |
| | | | 152. 96 27 33.05 49 54 26.85 | | | |
| | | | 153. 96 27 54.38 49 54 41.16 | | | |
| | | | 154. 96 28 01.33 49 54 44.85 | | | |
| | | | 155. 96 28 14.21 49 54 48.5 | | | |
| | | | 156. 96 28 29.77 49 55 04.94 | | | |
| | | | 157. 96 28 50.33 49 55 10.06 | | | |
| | | | 158. 96 29 13.6 49 55 19.03 | | | |
| | | | 159. 96 29 15.72 49 55 19.3 | | | |
| | | | 160. 96 29 31.92 49 55 21.39 | | | |
| | | | 161. 96 29 41.28 49 55 25.18 | | | |
| | | | 162. 96 29 59.26 49 55 29.66 | | | |
| | | | 163. 96 30 00 49 55 30.32 | | | |
| | | | 164. 96 30 00 49 20 00 | | | |
| | | | 165. 96 00 00 49 20 00 | | | |
| | | | 166. 96 00 00 49 59 04.78 | | | |
| | | | 167. 96 00 09.85 49 59 20.24 | | | |
| | | | 168. 96 00 25.11 49 59 26.11 | | | |
| | | | 169. 96 00 33.39 49 59 45.44 | | | |
| | | | 170. 96 00 47.71 49 59 57.49 | | | |
| | | | 171. 96 00 55.47 50 00 06.75 | | | |
| | | | 172. 96 01 07.72 50 00 13.67 | | | |
| | | | 173. 96 01 18.94 50 00 17.59 | | | |
| | | | 174. 96 01 30.44 50 00 16.07 | | | |
| | | | 175. 96 01 33.44 50 00 14.43 | | | |
| | | | 176. 96 01 35.55 50 00 13.26 | | | |
| | | | 177. 96 01 43.28 50 00 16.36 | | | |
| | | | 178. 96 01 43.37 50 00 16.5 | | | |
| | | | 179. 96 01 46.85 50 00 21.64 | | | |
| | | | 180. 96 01 53.76 50 00 22.45 | | | |
| | | | 181. 96 02 02.89 50 00 20.57 | | | |
| | | | 182. 96 02 10.46 50 00 19.01 | | | |
| | | | 183. 96 02 22.6 50 00 24.69 | | | |
| | | | 184. 96 02 32.62 50 00 29.37 | | | |
| | | | 185. 96 03 04.44 50 00 38.83 | | | |
| | | | 186. 96 03 19.7 50 00 37.97 | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 187. 96 03 24.97 50 00 37.83<br>188. 96 03 25.29 50 00 37.77<br>189. 96 03 34.75 50 00 36.08<br>190. 96 03 37.14 50 00 35.66<br>191. 96 03 51.21 50 00 36.66<br>192. 96 03 59.36 50 00 47.81<br>193. 96 04 08.27 50 00 42.48 | | | |
| 4 | Холбоо нуур-50<br>M-47-99-А,Б,В,Г<br>M-47-111-А, Б<br>M-47-110-А,Б<br>(2010-2012)<br>Код: ХН-50 | Завхан аймгийн Нөмрөг, Түдэвтэй, Тэлмэн сум, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сум | 1. 96 30 00 48 50 00<br>2. 96 30 00 49 00 00<br>3. 97 00 00 49 00 00<br>4. 97 00 00 49 20 00<br>5. 97 30 00 49 20 00<br>6. 97 30 00 48 50 00 | 2707.16 | 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийх | 2013 он хүртэл |
| 5 | Хүдлийн сэрвэн-50<br>L-46-94-А,Б<br>L-46-95-А,Б, В<br>(2010-2012)<br>Код: ХС-50 | Говь-Алтай аймгийн Бугат, Төгрөг, Цээл сум | 1. 94 30 00 45 30 00<br>2. 94 30 00 45 40 00<br>3. 95 30 00 45 40 00<br>4. 95 30 00 45 30 00<br>5. 95 15 00 45 30 00<br>6. 95 15 00 45 20 00<br>7. 95 00 00 45 20 00<br>8. 95 00 00 45 30 00 | 1814.6 | 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийх | 2013 он хүртэл |
| 6 | Бугатын нуруу-50<br>L-47-28-Б, Г<br>L-47-29-А,Б,В,Г<br>L-47-41-Б, Г<br>(2010-2012)<br>Код: БН-50 | Завхан аймгийн Отгон сум, Баянхонгор аймгийн Гурванбулаг, Баянбулаг, Хүрээмарал сум | 1. 97 45 00 47 00 00<br>2. 97 45 00 47 20 00<br>3. 98 30 00 47 20 00<br>4. 98 30 00 46 40 00<br>5. 98 15 00 46 40 00<br>6. 98 15 00 47 00 00 | 2816.15 | 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийх | 2013 он хүртэл |
| 7 | Хурц уул-50<br>L-47-19-В, Г<br>L-47-31-А,Б,В,Г<br>L-47-43-А,Б<br>(2010-2012)<br>Код: ХУ-50 | Баянхонгор аймгийн Гурванбулаг, Заг, Жаргалант сум | 1. 99 30 00 47 30 00<br>2. 99 30 00 46 50 00<br>3. 99 20 04.58 46 50 00<br>4. 99 20 01.46 46 50 36.63<br>5. 99 22 22.47 46 52 54.62<br>6. 99 19 31.47 46 54 19.62<br>7. 99 17 31.44 46 54 58.61<br>8. 99 11 31.45 46 54 37.63<br>9. 99 12 46.47 46 53 02.62<br>10. 99 15 06.62 46 50 00<br>11. 99 00 00 46 50 00<br>12. 99 00 00 47 30 00 | 2722.8 | 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийх | 2013 он хүртэл |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | Харцитын даваа-50<br><br>M-47-129-В, Г<br>M-47-141-А,Б,В,Г<br>M-47-142-В,Г<br>(2010-2012)<br>Код: ХД-50 | Архангай аймгийн Тариат, Өндөр-Улаан, Хөвсгөл аймгийн Галт сум | 1. 100 30 00 48 30 00<br>2. 100 30 00 48 10 00<br>3. 101 00 00 48 10 00<br>4. 101 00 00 48 00 00<br>5. 100 00 00 48 00 00<br>6. 100 00 00 48 09 34.46<br>7. 100 00 29.52 48 09 40.78<br>8. 100 00 05.53 48 10 43.79<br>9. 100 00 00 48 10 47.39<br>10. 100 00 00 48 30 00 | 2751.0 | 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийх | 2013 он хүртэл |
| 9 | Хүнүйн гол-50<br>M-47-143-А,Б,В,Г<br>M-47-144-А,Б,В,Г<br>(2010-2012)<br>Код: ХГ-50 | Архангай аймгийн Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Ихтамир, Батцэнгэл, Хайрхан сум | 1. 101 00 00 48 00 00<br>2. 101 00 00 48 20 00<br>3. 102 00 00 48 20 00<br>4. 102 00 00 48 00 00 | 2750.44 | 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийх | 2013 он хүртэл |
| 10 | Уран дөш-50<br>M-49-116-Б,В,Г<br>M-49-117-А,В,Г<br>(2010-2012)<br>Код: УД-50 | Хэнтий аймгийн Норовлин, Дадал, Баян-Адарга сум, Дорнод аймгийн Баян-Уул | 1. 112 14 00 49 00 00<br>2. 112 14 00 48 47 00<br>3. 112 30 00 48 47 00<br>4. 112 30 00 48 40 00<br>5. 111 30 00 48 40 00<br>6. 111 30 00 48 50 00<br>7. 111 45 00 48 50 00<br>8. 111 45 00 49 00 00<br>9. 111 51 31.53 49 00 00<br>10.111 52 14.96 48 59 05.86<br>11. 111 55 41.96 48 57 40.85<br>12. 112 00 02 48 57 01.91<br>13. 112 04 56 48 56 41.9<br>14. 112 04 54.61 49 00 00 | 1905.9 | 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил хийх | 2013 он хүртэл |
| Нийт | | | | Нийт талбай 24198.35 кв.км | | |

**Хаяг:**
"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420, 329612
Хэвлэлийн хуудас 2.5
**Индекс: 14003**